

АГУУЛГА

| | |
|---|----|
| НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ | 3 |
| 1.1. Төслийн ерөнхий мэдээлэл..... | 3 |
| 1.2. Төслийн хүчин чадал..... | 4 |
| ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ | 6 |
| 2.1. Төслийн байршил физик газарзүй..... | 6 |
| 2.2. Агаарын температур..... | 6 |
| 2.3. Хур тунадас, салхи | 6 |
| 2.4. Гадаргын усны нөөц, горим..... | 7 |
| 2.5. Хөрсөн бүрхэвч | 7 |
| 2.6. Ургамлан бүрхэвч..... | 7 |
| 2.7. Тусгай хамгаалалттай газар нутаг | 8 |
| 2.8. Төсөл хэрэгжих дүүргийн нийгэм эдийн засаг | 8 |
| ГУРАВДУГААР БҮЛЭГ. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ | 9 |
| 3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдэх ажил, осол эрсдлээс сэргээлийх арга хэмжээний биелэлт..... | 9 |
| 3.2. Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлт | 15 |
| 3.3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт..... | 15 |
| 3.4. Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажил | 16 |
| 3.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт | 17 |
| 3.6. Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний биелэлт..... | 17 |
| 3.7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр..... | 18 |
| 3.7.1. Агаарын хяналт шинжилгээ..... | 18 |
| 3.7.2. Хөрсний хяналт шинжилгээ | 24 |
| ДҮГНЭЛТ | 29 |

ЗУРГИЙН ДУГААР

| | |
|---|----|
| Зураг 1-1. Төслийн байршил..... | 3 |
| Зураг 1-2. Агуулахын дотор болон гадна талбайн харагдах байдал..... | 4 |
| Зураг 1-3. Бүтээгдэхүүн хадгалалт..... | 5 |
| Зураг 3-1. Гал унтраах дадлага сургалт | 10 |
| Зураг 3-2. Хашааны засвар | 11 |
| Зураг 3-3. Ажилчдын байрны засвар үйлчилгээ | 12 |
| Зураг 3-4. Гэрэлтүүлэгний засвар үйлчилгээ | 12 |
| Зураг 3-5. Газардуулгын эсэргүүцэл хэмжсэн протокол | 13 |
| Зураг 3-6. Авто зам болон явганы хүний тусгаарлалтын зурвас | 13 |
| Зураг 3-7. Аюулаас сэргээлийх тэмдэг тэмдэглэгээ | 14 |
| Зураг 3-8. Гал унтраах багаж хэрэгсэл..... | 14 |
| Зураг 3-9. Мод тарих үйл явц | 15 |
| Зураг 3-10. Ахуйн хог хаягдал ангилан ялгах хогийн сав | 16 |
| Зураг 3-11. Марафон тэмцээний үе | 16 |
| Зураг 3-12. Цэргийн 337-р анги..... | 17 |
| Зураг 3-13. Агаарын дах тоосонцруудын харьцангуй хамаарал | 20 |
| Зураг 3-15. Агаарын сорьц авч буй байдал..... | 21 |
| Зураг 3-16. Хүхэрлэг хийн агууламж..... | 22 |
| Зураг 3-17. Азотын давхар исэлийн агууламж..... | 22 |
| Зураг 3-18. Нийт тоосны агууламж..... | 23 |
| Зураг 3-19. Дуу чимээний үзүүлэлт | 23 |

ХҮСНЭГТИЙН ДУГААР

| | |
|---|----|
| Хүснэгт 3-1. Агаарын чанарын хэмжилт хийсэн цэгүүд..... | 20 |
| Хүснэгт 3-2. Агаарын чанарын сорилтын дүн 4-р сар..... | 21 |
| Хүснэгт 3-3. Агаарын чанарын сорилтын дүн 9-р сар..... | 21 |
| Хүснэгт 3-4. Талбайн хөрсний хими шинж чанар /2025 оны 4-р сар / | 25 |
| Хүснэгт 3-5. Талбайн хөрсний хими шинж чанар /2025 оны 9-р сар / | 26 |
| Хүснэгт 3-6. Талбайн хөрсний физик шинж /2025 он 4-р сар/..... | 26 |
| Хүснэгт 3-7. Талбайн хөрсний физик шинж /2025 он 9-р сар/..... | 26 |
| Хүснэгт 3-8. Талбайн хөрсний хүнд металлын агууламж /2025 он 4-р сар/ | 27 |
| Хүснэгт 3-9. Талбайн хөрсний хүнд металлын агууламж /2025 он 9-р сар/ | 28 |

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:

“Химийн бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах агуулах төсөл”

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:

“Орика Монголиа” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9019020020, Регистр: 2866838

Төслийн зорилго, ач холбогдол:

Олон улс болон Монгол улсын стандарт шаардлагад нийцсэн эмульсийн тэсрэх бодис хадгалах зорилготой. Агуулах нь химийн бодис хадгалах зориулалтын тавиуртай, зохиомол гэрэлтүүлэг хүрэлцээтэй, агаар сэлгэх салхивчтай, хана, шал нь химийн бодис хадгалахад тэсвэртэй материалаар хийгдсэн, 24 цагийн харуул хамгаалалттай. Төслийн талбайд нийт 12 ангор байрлаж байгаагаас “Орика Монголиа” ХХК нь 8 агуулахыг түрээслэн ашигладаг.


Төслийн цар хүрээ:

Оюу толгой ХХК-ийн лицензийн талбайд байрлах Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрлүүгээ түүхий эд буюу химийн болон тэсрэх бодисыг зориулалтын тээврийн хэрэгсэлээр цагдаагийн хяналтан дор энэ төрлийн зөвшөөрөлтэй гэрээт компаниар гүйцэтгүүлдэг.

Төслийн байршил:

Багахангай дүүрэг нь монгол улсын нийслэл Улаанбаатар хотоос зүүн урагш 90км-т байрлана.

Зураг 1-1. Төслийн байршил



1.2. Төслийн хүчин чадал

Олон улс болон Монгол улсын стандарт шаардлагад нийцсэн эмульсийн тэсрэх бодис хадгалах зорилготой. Агуулах нь химийн бодис хадгалах зориулалтын тавиуртай, зохиомол гэрэлтүүлэг хүрэлцээтэй, агаар сэлгэх салхивчтай, хана, шал нь химийн бодис хадгалахад тэсвэртэй материалаар хийгдсэн, 24 цагийн харуул хамгаалалттай. Төслийн талбайд нийт 12 ангар байрлаж байгаагаас “Орика Монголиа” ХХК 8 агуулахыг түрээслэн ашигладаг. Одоогийн байдлаар нийт 8 агуулахаас 5 хоосон, 3 агуулахад хадгалалтыг хийж байна.

Хүснэгт 1-1. Агуулахад хадгалагдаж буй бүтээгдэхүүн

| Агуулахын дугаар | Хадгалж буй бүтээгдэхүүн | Тоо ширхэг | Нэгж |
|------------------|----------------------------------|------------|------|
| Агуулах-1 | Эмульсжүүлсэгч SBI-120 | 113400 | Кг |
| Агуулах-2 | Хоосон | | |
| Агуулах-3 | Хоосон | | |
| Агуулах-4 | Зэс голтой угас | 420 | Ш |
| | Цахим тэслүүр | 22656 | Ш |
| | LP тэслүүр | 3314 | Ш |
| | Цохилтын долгион дамжуулах гуурс | 6 | Ш |
| Агуулах-9 | Хоосон | | |
| Агуулах-10 | FBRH-90 | 47600 | Кг |
| Агуулах-11 | Подон | 1080 | Ш |
| Агуулах-12 | Хоосон | | |

Химийн бодисын агуулахын байр нь химийн бодис хадгалахад тавигдах шаардлагын дагуу тусгай агуулахын өрөө гарган бэлтгэсэн бөгөөд агуулах нь 1 давхар, зоорьгүй, газардуулга, аянга зайлуулагчтай, бетон шалтай байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг хүрэлцээтэй, агаар сэлгэх механик салхивчтай, цонх нь төмөр тортой, дулаан, гадна талын хашаа нь блокон ханатай, 24 цагийн харуул хамгаалалттай, хүн ам бага суурьшсан хороолол, усан сан бүхий газар, үер, усны аманд байрлаагүй хийгдсэн байна.

Зураг 1-2. Агуулахын дотор болон гадна талбайн харагдах байдал





Зураг 1-3. Бүтээгдэхүүн хадгалалт



Төслийн талбай нь Багахангай өртөөнөөс 2 км буюу Батлан хамгаалах тусгай зориулалтын онгоц хадгалах болон аеродромын зориулалтаар ашиглаж байсан эдэлбэр газар байрлах бөгөөд Зэвсэгт хүчний 337 дугаар ангитай түрээсийн гэрээ байгуулан ажиллаж байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ

2.1. Төслийн байршил физик газарзүй

“Орика Монголиа” ХХК-ийн талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалтаар Хангай-Хэнтий уулархаг их муж, Хангайн дэд муж, Хэнтийн захын уулсын тойрогт хамаарна. Энэ дэд муж нь Монгол орны бараг төв хэсгийг эзлэн ойт хээрийн бүсийг голчлон багтааж оршихдоо Хангай-Хэнтийн уулархаг их муж дотор хамгийн их талбайг эзэлнэ. Түүний хил зааг баруун ба өмнө хэсэгтээ их мужийн хилтэй нийлж хойт талдаа Хөвсгөлийн уулс болон улсын хил, зүүн талдаа Хэнтийн уулсын захаар гарна. Энэ мужид Хангайн нуруу, түүний салбар уулсаас гадна, Сэлэнгэ-Орхоны сав газрын уулс багтах учир гадарга нь нийтдээ уулархаг боловч уулс жигд өндөр биш буюу өөрөөр хэлбэл өндөр уулын зэрэгцээ бэсрэг нам уул, цав толгод тархана.

“Орика Монголиа” ХХК-ийн талбай нь ойр орчим нь 1445.0-1538.0 м өндөржилттэй байна.

2.2. Агаарын температур

Тухайн бүс нутгийн цаг агаарын хүчин зүйлийн анхны тодорхойлолтыг агаарын температураар хэмждэг. Хотын газар зүйн байршлын онцлог нь агаарын температурт ихээр нөлөөлдөг бө энэ нь өвлийн улиралд илүү тогтвортой хүйтрэлтийг дагуулдаг. Зуны улиралд агаарын температурын дулааралт ажиглагдах өдрүүд олон жилийн дунджаар 4-7 өдөр тогтвортой үргэлжилдэг байна.

Энэ нь Улаанбаатар хотын бичил уур амьсгалын дулааны горим нь гадаад болон дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр өөрчлөгдөж байгааг онолын болоод бодит ажиглалтын материалд хийсэн дүн шинжилгээгээр нотлогдож байна. [Даваадорж.Д, Энхтуяа.Б, 2012]

Улаанбаатар хотод агаарын температурын хоногийн явцын агууриг өвлийн улиралд -10.5 градус байдаг бол 4-р сард + 21.3 градус байдаг. Хотын баруун хэсэг буюу буянт-Ухаа станцад температурын хоногийн явцын агууриг + 11.1 градус байдаг. Мөн олон жилийн дунджаар улаанбаатар хотод **өвлийн 113 хоногт нь хоногийн дундаж агаарын температур -15 градус, 136 хоногт нь -10 градусын хүйтэн** байдаг. Агаарын үнэмлэхүй бага температур Улаанбаатарт - 49 градус, үнэмлэхүй их температур +39 градус байдаг. Улаанбаатар хотын орчинд 1936-1980аад оныг хүртлэх хугацаанд хамгийн их үнэмлэхүй халуун нь 38.9 градус хүрч байсан. [Жамбаажамц .Б,1989] Монгол орны зуны улирлын температур 2011-2024 онд 0.5-3.1 градусаар нэмэгдэж дулаарсан нь 2023, 2024 онуудад хамгийн дулаан жил байсантай холбоотой.

Уур амьсгалын ерөнхий үзүүлэлтийг тухайн газар нутгийн агаарын дундаж температур, агаарын хамгийн их дулаан болон хамгийн хүйтэн, хур тунадасны жилийн дундаж нийлбэрээр тодорхойлдог.

Улаанбаатар хотын агаарын дундаж температур өвлийн улиралд -21°C хүйтэн, зуны улиралд +18°C дулаан байдаг. Агаарын үнэмлэхүй их температур нь өвлийн саруудад -9.7°C хүйтэн, зуны саруудад +27.5°C дулаан, агаарын үнэмлэхүй бага температур нь өвлийн саруудад -23.1°C хүйтэн, зуны саруудад +3.0°C дулаан байдаг. Нийт хур тунадасны 93.3 % нь дулааны улиралд, 6.7 % нь хүйтний улиралд оржээ

2.3. Хур тунадас, салхи

Улаанбаатар хотын жилд орох тунадасны 94.4 хувь нь дулааны улиралд, 5.6 хувь нь хүйтний улиралд ордог. Олон жилийн дунджаар дулааны саруудад 36-143 мм бороо, хүйтний саруудад 1-5 мм хатуу тунадас унадаг гэсэн тооцоо байдаг бол сүүлийн жилүүдэд орох тунадасны хэмжээ олон

жилийн дунджаас 0.8-1.4 дахин их байсан ч 2022 оноос тунадасны хэмжээ багасах төлөв ажиглагдаж байна.

Монгол орны нийт нутгаар сүүлийн жилүүдэд орох тунадасны хэмжээ эрс нэмэгдсэн. Үүнийг дагаад хүчтэй салхи, үер ус, аянга цахилгаан, мөндөр зэрэг байгалийн гамшигт үзэгдлүүд ихээр ажиглагдах болж мөн улс орон, ард иргэдийн эдийн засаг, амь насанд аюул учруулах болсон байна. 2016 оноос хойш 2020 оныг хүртэл Улаанбаатарт орох тунадасны хэмжээ эрс нэмэгдэж, жилд дунджаар 245-300 мм хур тунадас орж байна.

Хур тунадасны эрчимшилийг олон жилийн дундажтай харьцуулж авч үзвэл 6-9-р саруудад 0.3-1.4 хувиар ахиу, өвлийн саруудад 0.1-0.8 хувиар ахиу тунадас орж байна.

Монгол оронд хур тунадас ерөнхийдөө бага ордог. Хангайн нуруу, Хөвсгөл, Хэнтийн уулсаар 300-400мм, Монгол Алтайн болон ойт хээрийн бүсэнд 250-300 мм, хээрийн бүсэнд 150-250 мм, говь цөлийн бүсэд 150-50мм хур тунадас унадаг. Хур тунадас хойноос урагш, зүүнээс баруун тийшлэх тусам буурдаг ч түүний хувиарлалтанд газрын хотгор гүдгэрийн нөлөө их байдаг.

2.4. Гадаргын усны нөөц, горим

Монгол орны гол, мөрөн, түүний сав газрын хэмжээ, байгалийн нөхцөл, урсац бүрэлдэх зүй тогтол, нөөцийн хуваарьлалт, байгалийн болон засаг захиргааны хил хязгаарыг үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 332 дугаар тушаалаар Монгол орны нутаг дэвсгэрийг усны 29 сав газарт хувааж, хил хязгаарыг нь тогтоож өгсөн байдаг бөгөөд тус төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь Умард говийн гүвээт Халхын дундад талын сав газарт хамаарна. Умард говийн усны сав газар нь 8 аймаг, 59 сум, Нийслэлийн Багахангай дүүргийн газар нутгийг хамарсан нийт 180404.2 км² талбай бүхий говь, хээрийн бүсүүдийг хамарсан өргөн уудам нутаг юм. Тус сав газар нь Монгол орны 29 усны сав газрын хувьд талбайн хэмжээгээрээ 2 дугаарт орох бөгөөд далайн төвшнөөс дээш дунджаар 1267 метр өргөгдсөн өргөн уудам тал нутаг юм. Баруунаас зүүн хүртэл 858 км ба хойноос урагш 424 км бөгөөд нийт хилийн цэсийн урт нь 2700 км байна.

2.5. Хөрсөн бүрхэвч

Судалгаанд хамрагдсан тус талбай нь Хөрс-газарзүйн мужлалтаар өргөргийн бүшилтэй нутгийн Мааньтын 4-р тойрогт багтана. Хөрсний химийн шинжилгээний дүнгээр сайргархаг болон хужирлаг хүрэн хөрс ялзмагт бодисын агууламжаар бага, хөрсний дээд давхаргад 1,86 -1,93%-ийн хооронд хэлбэлзэнэ. Талхагдсан хөрсний дээд давхаргын ялзмагын агууламж буурч багассан үзүүлэлттэй. Сайргархаг хужирлаг хөрс бусад хөрснөөс давсны агууламжаар илүүтэй байгаагаар ялгаатай байна. Үүнтэй уялдаж хөрсний цахилгаан дамжуулах чанар хужирлаг хөрсөнд нэмэгдсэн байна. Нийт хөрсний урвалын орчин хөрсний 40-50 см гүн хүртлээ шүлтлэг ихтэй байгаа нь онцлогтой. Хөрс хагас метрийн гүн хүртлээ бага зэргийн хэмжээний карбонат агуулсан байна. Шингээгдсэн сууриудын нийлбэр их биш 100 г хөрсөнд 10,0-21,7мг/экв хүрч, сууриудаас кальцийн ион зонхилно. Шим тэжээлийн бодисын хангамжаар ургамалд хялбар ашиглагдах хөдөлгөөнт элемент фосфорын агууламжаар харилцан адилгүй бага болон дунд зэргийн хангамжтай, харин хужирлаг хүрэн хөрсөнд калийн элемент илүүтэй агуулагдсан онцлогтой байна.

2.5. Ургамлан бүрхэвч

Улаанбаатар хотын Багахангай дүүргийн нутагт байрлах хэсэг нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Дундад халхын хээрийн тойрогт хамаарагддаг. Хойд хэсгээр бэсрэг, дунд зэрэг өндөрлөгтэй нам уулсын нугархаг хээрт алаг өвс-хялганат, алаг өвс-хялгана-жижиг дэгнүүлт үетэнт, жижиг дэгнүүлт үетэнталаг өвст, жижиг дэгнүүлт үетэнт, алаг өвс-ботуульт, алаг өвс-үетэн-

ботуульт, ботуульалаг өвст, алаг өвс-үетэнт зэрэг бэлчээр зонхилон тохиолдоно. Уулын хоорондох хөндий, хотгорын нугархаг хээрээр алаг өвс-үетэнт, алаг өвс-жижиг үетэнт, алаг өвсботуульт, хялгана-жижиг үетэнт, алаг өвс-улалж-жижиг үетэнт, алаг өвс-үетэндаагансүүлт бэлчээр, уулсын хоорондох голын хөндийн хээржсэн нугын талбайд бургас, улиас бүхий үетэнт, алаг өвс-үетэнт, түнгэт, алаг өвс түнгэт, алаг өвсбуурцагтан-үетэнт, жижиг улалж-үетэнт, үетэн-жижиг улалжит бэлчээр тус тус тархана.

2.6. Тусгай хамгаалалттай газар нутаг

Төслийн талбайд улсын тусгай хамгаалалттай газар нутаг байхгүй бөгөөд Төв аймгийн улсын тусгай хамгаалалттай газар нутаг нийт нутаг дэвсгэрийн 13.9% буюу 10450.2 км² талбайг хамарна. Үүнд дархан цаазат газар 2, байгалийн цогцолборт газар 3, байгалийн нөөц газар 2 хамаарагдана.

Үүнээс төслийн талбайтай давхцалтай улсын тусгай хамгаалалттай газар нутаг байхгүй. Төслийн талбайтай хамгийн ойр байрлах тусгай хамгаалалттай газруудыг дурдвал: Богдхан уулын дархан цаазат газар 50 км, Нагалхаан уулын байгалийн нөөц газар 30 км тус тус байршиж байна.

2.7. Төсөл хэрэгжих дүүргийн нийгэм эдийн засаг

Багахангай дүүрэг нь монгол улсын нийслэл Улаанбаатар хотоос зүүн урагш 90км-т, далайн түвшнээс дээш 1614 метр өргөгдсөн 14 мянган км² нутаг дэвсгэртэй, баруун хойд талаараа Төв аймгийн Сэргэлэн сум, зүүн болон урд талаараа Баян сумтай хил залган оршдог. Нийслэлийн алслагдсан дүүргүүдийн нэг юм. Багахангай дүүрэг нь Улаанбаатар хоттой 107 км төмөр замаар, 90 км хатуу хучилттай хар замаар холбогдсон. Дүүргийн эрчим хүчний гол эх үүсвэр нь цахилгаан эрчим хүч бөгөөд төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон 35.0 кв-ын 200.0 км урт цахилгаан дамжуулах шугамтай, 2500 квт-ын хүчин чадалтай 4 дэд станц эзэмшин эрчим хүчээр жилдээ 160 сая төгрөгийн борлуулалт хийж байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Улаанбаатар хотын Багахангай дүүргийн нутагт орших “Орика Монголиа” ХХК-ийн химийн бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах агуулах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулахдаа БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримталсан бөгөөд тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлтийн байдлыг нэг бүрчлэн тодорхойлж, шаардагдсан хөрөнгө зардлыг тооцсон бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хэсэгт хяналт шинжилгээний ажлын үр дүнг дэлгэрэнгүй хэлбэрээр тусгасан болно.

3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдэх ажил, осол эрсдлээс сэргээлийх арга хэмжээний биелэлт

Агааржуулалтын тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг тогтмол шалгаж, засвар үйлчилгээг тогтмол хийж, тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан хадгалах нөхцөлийг хангасан орчныг бүрдүүлж, уурших, халах нөхцөлөөс бүрэн сэргийлж ажиллаж байна.

Зураг 3-1. Агуулахын дотоод орчин



Химийн болон тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлт, хадгалалтын горим зөрчигдөх, гэнэтийн осол, санамсар болгоомжгүй байдлаас химийн бодис асгарч алдагдах, тэсэрч дэлбэрэх тохиолдолд ашиглах багаж, хэрэгсэл, шингээгч материал, хувийн хамгаалах хэрэгслийг ажлын байранд байршуулж, ажилчдад ашиглах дадлыг эзэмшүүлэн ажиллаж байна.

Зураг 3-2. Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл, асгаралтын үед ашиглах багц



Ажилтнууддаа ХХАА-ны дүрэм журам, химийн болон тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй харилцах, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг хэрэглэх, эрсдэл, аюул, ослын үед авах арга хэмжээ, ослыг хэрхэн мэдээлж, тусламж дуудах талаар сургалтыг тогтсон хугацаанд зохион байгуулж зохих мэдлэг, дадлыг эзэмшүүлэх үүднээс 2025 оны 08-р сарын 29-нд Багахангай дүүргийн онцгой байдлын хэлтсээс онцгой байдал болон гал унтраах дадлага сургалтанд хамрагдсан. Сургалтаар гал түймэр гарсан үед анхан шатны багаж хэрэгслүүдийг хэрхэн ашиглах, гал түймрийн үед хэрхэн ажиллах, хэрхэн гал түймрээс өөрийгөө болон бусдыг аюулгүй гаргах, галыг хэрхэн зөв унтраах зэрэг мэдлэг мэдээллийг ажилчдад олгосон.

Зураг 3-3. Гал унтраах дадлага сургалт






Химийн болон тэсрэх бодис асгарахаас сэргийлж бетонон хашаанд засвар хийж тэмдэг тэмдэглэгээг байршуулсан.

Зураг 3-4. Хашааны засвар



Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй нөхцөлд ажиллаж, амрах таатай нөхцөлийг бүрдүүлэх үүднээс ажилчдын байрны тааз болон агааржуулалтын системийг шинэчилж гадна хаяавчийг бетонон хучилттай болгосон.

Зураг 3-5. Ажилчдын байрны засвар үйлчилгээ



Төслийн талбайн ойр ойрчмын аюулгүй байдлыг хангах үүднээс 7 гэрэлтүүлэгт засвар үйлчилгээг хийж гүйцэтгэсэн.

Зураг 3-6. Гэрэлтүүлэгний засвар үйлчилгээ



Байгалийн давтагдашгүй хүчин зүйл болох аянганаас сэргийлж 4 аянга зайлуулагчийн тоноглолд эсэргүүцлийн хэмжилтийг хийлгэсэн. Аянга зайлуулагч нь аянгад тэнцэнэ гэсэн үнэлгээ авсан.

**УЛААНБААТАР ХОТЫН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НУТАГТ ОРШИХ “ОРИКА МОНГОЛИА” ХХК-ИЙН
“ХИМИЙН БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЭЛ ХАДГАЛАХ АГУУЛАХ” ТӨСЛИЙН 2025 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Зураг 3-7. Газардуулгын эсэргүүцэл хэмжсэн протокол

ГАНТЕСЛА ТОНОГЛОЛЫН ГАЗАРДУУЛГЫН ЭСЭРГҮҮЦЭЛ
ХЭМЖСЭН ТУХАЙ ПРОТОКОЛ № 3080

2025 оны 10 сарын 08 өдөр

Хэвцэлт туршилт захиалгач: Орика Монголиа ХХК

Газардуулгын байгууламжийн зургийг хийсэн урлаг төслийн эрх бүхий компани: X

Газардуулгын байгууламжийг хийсэн шалтгаан үргэлжт эрх бүхий компани: X

Техникийн нөхцөлийн дугаар: _____ Огноо: _____ он _____ сар _____ өдөр

Хэвцэлт хийсэн Байгаль: Амгисур Байгаль Багагаажуулсан: 2025 он 01 сар 20 өдөр

Нур: МБЭЗ.02 Зовод №: 02-43889 Үйлдвэрлэсэн он: 2020

Хөвчлөх арга, аргачлал, НТББ: БД 43-101-03, СД 43-101-03/12, MNS 5146:2002

| № | Байгууламжийн нэр, хаяг | Газардуулгын тоноглолын нэр | Газардуулгын нэвтрүүлэлт (См) | | Дүнхлэл |
|----|-------------------------|-----------------------------|-------------------------------|------------|---------|
| | | | Байгаль зохилт | Хэмжээгээр | |
| 1 | Басгалтай дүүрэг | Авгуурын-10, авгины бүрэлд | 30 | 4,01 | Төвөг |
| 2 | | Авгуурын-9, авгины бүрэлд | 30 | 2,64 | Төвөг |
| 3 | | Авгуурын-1, авгины бүрэлд | 30 | 5,64 | Төвөг |
| 4 | | Авгуурын-4, авгины бүрэлд | 30 | 6,04 | Төвөг |
| 5 | | | | | |
| 6 | | | | | |
| 7 | | | | | |
| 8 | | | | | |
| 9 | | | | | |
| 10 | | | | | |

Дүнхлэл: Амгисур нөхцөл халсан байна

Хэвцэлт, туршилтын үр дүнд: Т. Төрбаяр, У. Ганзориг, Т. Төрбаяр

Хийсэн: Т. Төрбаяр, У. Ганзориг, Т. Төрбаяр

ХТБ-ны дарга: _____

Химийн бодис тээвэрлэсэн авто машин зорчих, авто зам болон явган хүний замын тусгаарлалтын зурвасыг хийж, тэмдэг тэмдэглэгээг байршуулсан.

Зураг 3-8. Авто зам болон явганы хүний тусгаарлалтын зурвас



Аврах зам, гарц, цугларах цэг, анхны тусламжийн хайрцаг, хэрэгслийн байршил, хориглох тэмдэг, химийн бодис хадгалах агуулахад хадгалагдаж буй бодисын тэмдэг тэмдэглэгээ, мөн зүг чиглэлийн заасан тэмдэглэгээг нүдэнд ил харагдахуйцаар байрлуулсан.

Зураг 3-9. Аюулаас сэргээлийх тэмдэг тэмдэглэгээ



Болзошгүй гал түймрийн үед ашиглах усан сан, гал эсэргүүцэх галын хор, элс, шат, хувин, лоом, хүрз, зээтүү бүхий иж бүрэн галын сарайг цэгүүдэд байршуулсан.

Зураг 3-10. Гал унтраах багаж хэрэгсэл



3.2. Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлт

Багахангай дүүрэг дэх “Орика Монголиа” ХХК-ийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнд Хайлаас 150 ширхэг, Голт бор 20 ш тус тус 170 ш мод тарьсан. Модыг тарих явцад эхлээд талбайн хашааны дотор талаар нийт 50 м урттай газар зурвас үүсгэн, 60 см-ийн өргөнтэй шуудуу ухаж бэлтгэсэн. Ухсан шуудууны дээд түвшнээс 60 см хүртэл гүнд хайлаас модыг үндсээр нь суулгаж тарьсан.

Зураг 3-11. Мод тарих үйл явц



3.3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдал нь аюултай хог хаягдлын ангилалд багтах бөгөөд 2024 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах эрх бүхий “Элемент” ХХК-тай “Химийн хорт болон аюултай бодисын хаягдал тээвэрлэх, устгах №ХБ-25/028 тоот гэрээ”-г 1 жилийн хугацаатай байгуулсан. Тус гэрээнд хог хаягдлыг ангилан ялгаж “Аюултай хог хаягдал” гэсэн тэмдэглэгээтэйгээр шилжүүлэх бөгөөд аюултай хог хаягдлын тоо хэмжээг тодорхойлон тээвэрлэлтийг тусгай зөвшөөрөл бүхий ААН-ийн тээврийн хэрэгслээр гүйцэтгэхээр заасан байна.

Тус агуулахад үйл ажиллагаа хариуцсан менежер, хөдөлмөрийн аюулгүй байдлын ажилтан, цахилгаанчин ажиллана. Харуул хамгаалалтад 3 хүн ээлжээр ажиллах бөгөөд байнгын 1 хүн байрлаж ажиллана. 1 хүн хоногт дунджаар 0.5 кг хог хаягдал үүсгэнэ гэж тооцвол жилд 4 хүнээс 730 кг хог хаягдал гарна.

Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн зэрэг шаардлагуудыг хангасан хогийн савыг тус агуулахын хог хаягдал хамгийн их үүсдэг хэсгүүдэд байршуулах шаардлагатай. Хогийн саванд цугларсан хогны ангилалыг дахин шалгаж хог хаягдал түр хадгалах цэгт хадгална. “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”-ыг баримталж ажиллаж байна.

Багахангай дүүргийн тохижилт үйлчилгээний компанитай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулан жил бүр сунган хамтран ажиллаж байна.

Зураг 3-12. Ахуйн хог хаягдал ангилан ялгах хогийн сав



3.4. Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажил

Монгол улсад хэт холын марафон гүйлт үүсэж хөгжсөний түүхт 66 жил, Холбоо байгуулагдсаны 15 жилийн ойн хүрээнд 14 дэх жилдээ 2025.05.03-ны өдөр Багахангай дүүрэгт амжилттай зохион байгуулагдсан. Тус арга хэмжээний хүрээнд “Орика Монголиа” ХХК нь ивээн тэтгэн оролцсон.

Зураг 3-13. Марафон тэмцээний үе



Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн 63.2 м² цонхыг шинээр солиж суурилуулсан.

Зураг 3-14. Цэргийн 337-р анги



3.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт

“Орика Монголиа” ХХК-ийн “Химийн бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах агуулах” төслийн талбайд одоогоор түүх, соёлын өв, дурсгалт олдвор тэмдэглэгдээгүй бөгөөд хэрвээ олдвор олдвол Соёлын өвийг хамгаалах хуулийн дагуу арга хэмжээ авах, олдворыг гэмтээхгүйгээр үйл ажиллагааг түр зогсоож, хорооны хэсгийн цагдаа, хорооны дарга, соёлын өвийн судалгааны байгууллагад мэдэгдэнэ.

3.6. Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний биелэлт

Улаанбаатар хотын Багахангай дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжиж байгаа “Орика Монголиа” ХХК-ийн химийн бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах агуулах төсөл нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар Багахангай дүүргийн 1-р хорооны иргэд, Нийслэлийн байгаль орчны газар, БОУАӨЯ-д тайланг жил бүр хүргүүлэн дүгнүүлж ажиллаж байна.

3.7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

3.7.1. Агаарын хяналт шинжилгээ

Төслийн талбайд хийсэн агаарын чанарын судалгааны ажилд Монгол улсын “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2025” стандартыг мөрдлөг болгон ажилласан. Уг стандартын дагуу нэг удаагийн хэмжилтээр азотын давхар исэл 200 мг/м³, хүхэрлэг хий 450 мг/м³, РМ10 тоосонцор 100 мг/м³-ийг давах ёсгүй юм. Азотын давхар исэл, хүхэрлэг хийн шинжилгээг Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторид шинжлүүлэв.

3.7.1.1. Агаарын судалгааны аргазүй

Төслийн талбайд агаарын чанарын хэмжилтийг гүйцэтгэхдээ тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан цэгүүдийг болон үүсэж болзошгүй түгээмэл бохирдуулагчдыг сонгон тодорхойлсон. Монгол улсын Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2025 стандартыг мөрдлөг болгон ажилласан.

| Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS4585:2025 стандарт | | | | |
|--|---|---|--------------------|--------------------------------------|
| № | Үзүүлэлтийн нэр | Хэмжилтийн дундаж хугацаа | Хэмжих нэгж | Хүлцэх агууламж, зөвшөөрөгдөх түвшин |
| Химийн нөлөөлөл | | | | |
| 1 | Хүхэрлэг хий (SO ₂) | 20 минутын дундаж 24 цагийн дундаж Жилийн дундаж | мкг/м ³ | 450 50 20 |
| 2 | Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) | 20 минутын дундаж 1 цагийн дундаж 8 цагийн дундаж | мкг/м ³ | 60000 30000 10000 |
| 3 | Азотын давхар исэл (NO ₂) | 20 минутын дундаж 24 цагийн дундаж Жилийн дундаж | мкг/м ³ | 200 50 40 |
| 4 | Озон (O ₃) | 8 цагийн дундаж | мкг/м ³ | 100 |
| 5 | Тоос (Нийт жинлэгдэгч бодис) | 20 минутын дундаж 24 цагийн дундаж Жилийн дундаж | мкг/м ³ | 500 150 100 |
| 6 | Том ширхэглэгт тоосонцор (PM 10) | 24 цагийн дундаж Жилийн дундаж | мкг/м ³ | 100 50 |
| 7 | Нарийн ширхэглэгт тоосонцор (PM 2.5) | 24 цагийн дундаж Жилийн дундаж | мкг/м ³ | 50 25 |
| 8 | Хар тугалга (Pb) | 24 цагийн дундаж Жилийн дундаж | мкг/м ³ | 1 0.5 |
| 9 | Бенз-а-пирен (C ₂₀ H ₁₂) | 24 цагийн дундаж | мкг/м ³ | 0.001 |
| Физикийн нөлөөлөл | | | | |
| 10 | Дуу шуугиан | 16 цагийн дундаж | дБА | 100 |

Шинжилгээний болон хэмжлийн арга аргачлалын үндсийг товч авч үзье.

Хүхэрлэг хий: Төслийн талбай орчмын агаараас 2 л/мин хурдтайгаар 20 минутын турш тетраклормеркуратын натрийн уусмал (ТХМ)-аар норгосон шингээгч гуурсанд соруулахад шингээгч гуурсны шилэн бөмбөлөгийн давхаранд шингэсэн хүхэрлэг хийг лабораторын нөхцөлд уусмал шилжүүлж тэр уусмал дээрээ формальдегид парапозанадины уусмал нэмэхэд үүссэн нэгдлийн өнгөний эрчимшлийг спектрофотометрээр хэмжин хүхэрлэг хийн хэмжээг тодорхойлно.

Азотын давхар исэл: Агаараас азотын давхар ислийг үл хатах мышьяклаг хүчлийн натрийн давс агуулсан кали иодын уусмалаар норгосон шингээгч гуурсаар 0.25 л/мин-ын хурдтайгаар 20 минутын турш соруулан авахад шингээгч гуурсны шилэн бөмбөлөгийн давхаргаанд шингээж лабораторын нөхцөлд уусмалд шилжүүлж үүссэн нитрит ион сульфанадины хүчилтэй харилцан үйлчилж диазонэгдлийг үүсгэх бөгөөд тэр нь α нафтиламинтай урвалд орж азобудагч бодисыг уусмалын өнгөний эрчимшлээр азотын давхар ислийн хэмжээг тодорхойлдог.

Тоос: Агаар дахь тоосны агууламжийг Dusttrack 8530 маркийн зөөврийн автомат багажаар тодорхойлсон бөгөөд энэ багаж нь агаар дахь нийт тоос PM_{10} хэмжээтэй тоосыг хугацааны өргөн завсарт хэмжиж, хэмжилтийн хугацаанд тоосны агууламжийн хамгийн их, хамгийн бага, дундаж утгыг хэмжих боломжтой байдаг.

Агаар бохирдуулах бодисуудын тодорхойлолт

Хүхэрлэг хий SO_2 - Өнгөгүй, хурц үнэр, амттай, урвалд идэвхтэй ордог хий. Нүүрс, газрын тос зэрэг хүхэр агуулсан бүх төрлийн түлшний шаталт, металл боловсруулах үйл ажиллагааны дүнд үүсдэг. Орчны агаар дахь хүхэрлэг хийн агууламж нэмэгдэх нь олон талын сөрөг нөлөөлөлтэй ба өндөр агууламжтай үед гуурсан хоолойн багтраа өвчтэй хүмүүс гадаа биеийн хүчний ажил хийж байгаа үед хүхрийн давхар исэлд их өртөмтгий байдаг. Гол нөлөө нь амьсгалын замыг нарийсгадаг бөгөөд шуухитнах, амьсгаа давчдах зэрэг шинж тэмдгүүд илэрдэг. Хүхрийн давхар исэл нь амьсгал цочроосноос найтаах, ханиах зэрэг физиологийн хариу үйлдэл үзүүлэх бөгөөд сөрөг нөлөө зогсоход уушгины үйл ажиллагаа цагийн дотор хэвийн байдалд ордог. Хүхрийн давхар ислийн архаг нөлөө нь амьсгалын замын өвчний тохиолдлыг ихэсгэх, уушгины хамгаалах механизмыг бууруулах, зүрх судасны архаг өвчнийг сэдэрээдэг. Зүрх судасны өвчтэй болон уушгины архаг өвчтэй хүмүүс, түүнчлэн хүүхдүүд, өндөр настнууд архаг нөлөөнд өртөмтгий байдаг. Мөн хүчиллэг тунадас (H_2SO_4) үүсгэх зэргээр хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, дэд бүтэц зэрэг бүхий л салбарт сөргөөр нөлөөлдөг.

Азотын давхар исэл NO_2 -Азотын давхар исэл нь азот агуулсан түлшний шаталт болон өндөр температурт шаталтын бүтээгдэхүүн бөгөөд ихэвчлэн шаталтын үеийн дулаан шингээх урвалын үр дүнд үүсдэг өнгөгүй, үнэргүй хий бөгөөд агаар мандалд бор шаргал өнгөтэй болдог. Азотын давхар исэл нь уушгины эдийг цочроох ба амьсгалын замын халдварт өртөмтгий байдлыг нэмэгдүүлдэг. Азотын давхар исэл нь амьсгалын замын өвчний тохиолдлыг ихэсгэх, гуурсан хоолойн багтраа болон үрэвсэлтэй хүний мэдрэгшлийг нэмэгдүүлэх, уушгины хамгаалах механизмыг бууруулах, зүрх судасны архаг өвчнийг сэдэрэх нөлөөтэй. Зүрх судасны, уушгины архаг өвчтэй хүмүүс, түүнчлэн хүүхдүүд, өндөр настнууд архаг нөлөөнд өртөмтгий байдаг.

Тоосонцор ($PM_{1.0}$, $PM_{2.5}$, $PM_{4.0}$, PM_{10} , нийт тоос TSP). Агаарын чанарын судалгаанд тоос тоосонцор гэдэг нь маш өргөн хүрээг хамарсан ойлголт бөгөөд үүсэж буй эх үүсвэр, агаар мандал дахь физик химийн урвалаас хамаараад маш жижиг буюу нано хэмжээнээс эхлээд хэдэн арван микрон хүртэлх ширхэглэгийн хэмжээтэйгээр илэрдэг.

Байгалийн эрдэс минералууд болон биологийн гаралтай тоос тоосонцор харьцангуй том ширхэглэгийн хэмжээтэйгээр агаар мандалд илэрдэг бол бүх төрлийн түлшний шаталтаас үүдэлтэй

тоосонцор нь хэмжээний хувьд маш жижиг байхаас гадна хортой химийн элементүүдийг агуулж байдаг. 10 микроноос том ширхэгтэй тоос тоосонцор нь хамар ам, мөгөөрсөн хоолойд баригдаж гадагшилдаг бол 10 микроноос бага диаметртэй тоос /PM10/-ны ширхгүүд нь эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг. Тухайлбал, 2.5-10 микрометр диаметр бүхий тоосны ширхгүүд нь уушгины мөгөөрсөн хоолой болон хялгасан судлуудад хуримтлагдах, харин 2.5 микроноос бага диаметртэй ширхгүүд нь уушгины цулцангуудад шигдэх аюултай байдаг.

Зураг 3-15. Агаарын дах тоосонцруудын харьцангуй хамаарал



3.7.1.2. Агаарын чанарын төлөв байдал

“Орика Монголиа” ХХК-ийн Химийн бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах агуулах төслийн талбай Улаанбаатар хотын Багахангай дүүргийн нутаг дэвсгэрт байрладаг. Төслийн талбай орчмын агаарын чанарыг тодорхойлох зорилгоор 2025 оны 04-р сар болон 9-р сард хоёр удаагийн давтамжтай агаарын чанарын шинжилгээг 2 цэгт хийж гүйцэтгэв. Агаарын хэмжилт хийсэн цэгийн байршилыг дараах зургаар үзүүлэв.

Хүснэгт 3-1. Агаарын чанарын хэмжилт хийсэн цэгүүд

| Д/д | Солбицол | | Өндөршил | Байршил |
|-----|------------|-----------|----------|----------------------------|
| | Уртраг | Өргөрөг | | |
| 1 | 107.4520 | 47.363258 | 1465 м | Хашаан дотор агуулах орчим |
| 2 | 107.452648 | 47.363489 | 1462 м | Хашааны гадна |

Зураг 3-16. Агаарын сорьц авч буй байдал



Цаг уур, орчны шинжилгээний газрын Байгаль орчин хэмжилзүйн төв лабораторит 2025 оны 04-р сар болон 9-р сард шинжилсэн агаарын чанарын сорилтын дүнг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 3-2. Агаарын чанарын сорилтын дүн 4-р сар

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий мг/м ³ | Азотын давхар исэл мг/м ³ | Нийт тоосны агууламж /TSP/ мг/м ³ | Дуу чимээ /ДБА |
|--|----------------------------|------------------|-----------------|--------------------------------|--------------------------------------|--|----------------|
| 1 | Хашаан дотор агуулах орчим | 04/24 | 14:00 | 0.012 | 0.024 | 0.18 | 40 |
| 2 | Хашааны гадна | 04/24 | 14:30 | 0.014 | 0.015 | 0.21 | 42 |
| Агаарын чанарын стандарт MNS 4585:2025 | | | | 0.450 | 0.200 | 0.500 | 100 |


Хүснэгт 3-3. Агаарын чанарын сорилтын дүн 9-р сар

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий мг/м ³ | Азотын давхар исэл мг/м ³ | Нийт тоосны агууламж /TSP/ мг/м ³ | Дуу чимээ /ДБА |
|--|----------------------------|------------------|-----------------|--------------------------------|--------------------------------------|--|----------------|
| 1 | Хашаан дотор агуулах орчим | 09/11 | 09:40 | 0.015 | 0.028 | 0.105 | 44 |
| 2 | Хашааны гадна | 09/11 | 10:20 | 0.017 | 0.020 | 0.071 | 45 |
| Агаарын чанарын стандарт MNS 4585:2025 | | | | 0.450 | 0.200 | 0.500 | 100 |


Хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, экосистемийн тэнцлийг хангах зорилгоор хүрээлэн байгаа агаар болон аливаа орон байрны доторх орчны агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээг тогтоосон стандартын үзүүлэлттэй сорилтын дүнг харьцуулахад агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх агууламж болон физикийн сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй байгаа болно.

Цаг уур, орчны шинжилгээний газрын Байгаль орчин хэмжилзүйн төв лабораторит шинжилсэн агаарын чанарын сорилтын дүнг хавсралт хэсэгт оруулсан болно.


Зураг 3-17. Хүхэрлэг хийн агууламж



Зураг 3-18. Азотын давхар исэлийн агууламж



Зураг 3-19. Нийт тоосны агууламж




3.7.1.3. Физик бохирдол

Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр, талбайн орчим дахь физик бохирдолд дуу чимээ, доргио чичиргээ, цацраг идэвхт бодисын эх үүсвэрүүд зэргийг авч үзнэ.

Дуу шуугиан: Байгальд янз бүрийн давтамжтай дуу чимээ үүсэж байдаг хэдий ч дуу чимээний давтамж, далайц нэмэгдэхийн хэрээр орчинд шуугианыг үүсгэдэг. Шуугиан нь орчны чанарыг илэрхийлэх физик бохирдуулагчдын нэг бөгөөд зарим улс оронд лабораторийн туршилтаар шуугиан зүрх судасны өвчлөлд хэрхэн нөлөөлж байгааг судалсан байдаг. Судалгаагаар урт хугацааны туршид дуу шуугианы өндөр түвшний нөлөөлөлд өртөж байсан хүн зүрхний шигдээсээр үхэх эрсдэл нэмэгддэг болохыг тогтоосон байна. Мөн эрэгтэй хүмүүсийн цусны даралт ихсэх эрсдэл нэмэгддэг болох нь туршилтаар нотлогдсон байдаг. Дуу чимээний үүсэх, тархах онцлог нь байгаль, цаг уур, гадаргын байдлаас ихээхэн хамаарах ба хүлээн авагчид мэдрэгдэх байдлаараа тодорхой түвшнээс их болсон үед шуугиан болж тодорхойлогддог. Төслийн талбайд хэмжилт хийсэн дуу чимээний үзүүлэлтийг доор харуулав.

Зураг 3-20. Дуу чимээний үзүүлэлт



Улаанбаатар хотын Багахангай дүүргийн нутаг дэвсгэрт байрлах “Орика Монголиа” ХХК-ийн “Химийн бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах агуулах” төслийн талбайд хэмжсэн хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоосны агууламж, дуу чимээний үзүүлэлт нь агаарын чанарын стандарт MNS 4585:2025 стандартаас даваагүй хэвийн хэмжээнд байна.

3.7.2. Хөрсний хяналт шинжилгээ

Судалгаанд хамрагдсан Химийн бодисын агуулахын байрлал нь Багахангай дүүргийн орон сууцны хороололоос хойш орших зэлүүд, тэгш хээр газарт хамарна. Тус агуулах нь эргэн тойрондоо 1.8-2 м өндөр зузаан цементэн хашаагаар- хүрээлэгдсэн, орох хаалга нь урд хэсэгт нь байрлана. Хашаан дотор газарт гүн суулгагдсан нийт 8-12 тооны /“Ангор” нэртэй/ агуулахууд хоорондоо 300-500 м зайтай байрлана. Агуулахын дээд “дээвэр” хэсэг нь зузаан үетэй хөрс шороогоор нягтруулж хучилт хийж, хөрсжүүлж далдлагдсан онцлогтой. Агуулахуудын хоорондох тэгш талбайн хөрс нь 50-60 см өндөр ургасан өвслөг ургамлаар бүрхэгдсэн, хөрсний гадаргад жижиг, дунд зэргийн хэмжээний чулуу ихтэй, их нягтарсан онцлогтой байна. Агуулахын талбайн гадаргуу нь хойноосоо урагш чиглэсэн бага зэргийн /20-30 хэмтэй/ налуу газрыг хамарна.

Судалгаанд хамрагдсан тус талбай нь Хөрс-газарзүйн мужлалтаар өргөргийн бүсшилтэй нутгийн Мааньтын 4-р тойрогт багтана.

Агуулахуудын хоорондох талбайд хээрийн сайргархаг хүрэн болон нимгэн ба дунд зэргийн зузаантай хүрэн хөрс зонхилон тархана. Нийт талбайн гадаргуу сайн ургамалжсан, өнгөн гадарга нь ил гарсан хөрстэй газар багатай. Энэ нутгийн хээрийн хөрсний чийгийн хангамж төдий л сайн биш, зуны хур борооны үед хөрсөнд дөнгөж 20-40 см хүртэл чийг нэвчдэг, өвлийн улиралд 2,8-3,5 м гүн хөлдөх боловч -10°C-ийн температур 60 см-ээс доош бараг нэвтэрдэггүй. Зуны цагт хүчтэй халж +10°C-ийн температур хөрсөнд гүн нэвтэрдэг онцлогтой.

Хөрсний морфологи бичиглэл-1

Зүсэлтийн дугаар

2025-01

Координат N 47°21'46.00"

E 107°27'00.06"



Газрын гадарга, байршил

Тэгш, талбайн зүүн хэсэгт

Хөрсний нэр

Сайргархаг зузаан хүрэн

Фото

Гүн, см

Морфологи бичиглэл



A 0-20

Өнгөн гадаргад болон хөрсний дээд давхаргад чулуурхаг, чулуутай, улаандуу туяатай хүрэн, чийг багатай, их нягт, ургамлын урт богино үндэс ихтэй, пургисан тоосорхог элсэнцэр, сул бүтэцтэй, шилжилт алгуур

AB 20-32

Чийг багатай, цайвартсан хүрэн болон шаргалдуу туяатай хүрэн, ургамлын нарийн богино үндэстэй, том жижиг чулуу ихтэй, нягтарсан, чийг багатай, хөнгөн шавранцар, пургисан, сул тоосорхог бөөмөрхөг бүтэцтэй, давхаргын доод хэсгээр жижиг чулуутай, чулууны агууламж багасана

BCa 32-50

Хөрсний морфологи бичиглэл-2

Зүсэлтийн дугаар

2025-02

Координат N 47°21'49.08"

E 107°26'53.73"



Газрын гадарга, байршил
 Хөрсний нэр
 Фото



Тэгш нам газар талхагдсан
 Чулуун хучаастай сайргархаг хүрэн



Гүн, см Морфологи бичиглэл
 Хөрс ихээр нягтарсан газар, бага чийгтэй, тод хүрэн өнгийн, жижиг үйрмэг чулуу ихтэй-70% хүрнэ, өнгөн гадаргад хатсан ургамлын бүрхэц ихтэй, хөрсний чийг багатай, пургисан тоосорхог, хөнгөн шавранцарт ойр элсэнцэр, бүрэлдэхүүнтэй шилжилт өнгөөр тод
 А 0-10 Дээд давхаргыг бодвол арай гэгээлэг хүрэн өнгийн, чийг багатай, их нягт, жижиг чулуу ихтэй, чулуу нь хөрстэй барьцалдсан,
 В 10-20 хөнгөн шавранцар, элсэнцэр бүрэлдэхүүнтэй, ургамлын үндэс цөөн, үе давхарга доошлоход чулууны агууламж ихсэнэ.
 ВС 20-40

3.7.2.1. Хөрсний үржил шимийн түвшин ба хими-физик шинж чанарын төлөв байдал

Хөрсөнд үзүүлэх хүний нөлөөлөл, ачаалал тун бага /бараг байхгүй/ учраас урьд өмнө хийгдсэн шинжилгээний дүнг энэ онд явуулсан судалгааны дүнтэй нэгтгэн харьцуулалт хийж, /Мониторинг/ дүгнэлт өгөх нь судалгааны чанартай холбоотой юм. Ийм учраас тус талбайн хэмжээнд судлагдсан хөрсний хими шинж чанарын үзүүлэлтийг нэгтгэн оруулав.

Хүснэгт 3-4. Талбайн хөрсний хими шинж чанар /2025 оны 4-р сар/

| Зүсэлт дугаар | Дээж авсан гүн, см | pH /H ₂ O/ | ЕС _{2,5} /ds/m | Давс % | Ялзмаг % | СО ₂ % | ио з | Солилцоот суурь мг-экв /100 г | | Шим тэжээлийн элемент мг/100г | |
|---------------|--------------------|-----------------------|-------------------------|--------|----------|-------------------|------|-------------------------------|------------------|-------------------------------|------------------|
| | | | | | | | | Са ⁺² | Мг ⁺² | Р ₂ О ₅ | К ₂ О |
| 25-01 | 0-20 | 8.67 | 0.168 | 0.08 | 0.97 | 0.82 | 0.35 | 13.1 | 5.6 | 2.5 | 24 |
| | 20-32 | 8.15 | 0.071 | 0.03 | 1.93 | 0.96 | 0.41 | 11.6 | 9.8 | 2.7 | 24 |
| | 32-50 | 8.21 | 0.069 | 0.03 | 0.71 | 1.60 | 0.36 | 7.4 | 4.1 | 1.9 | 23 |
| 25-02 | 0-10 | 8.74 | 0.352 | 0.17 | 1.86 | 0.44 | 4.28 | 25.7 | 11.1 | 2.6 | 85 |
| | 10-40 | 8.95 | 0.250 | 0.12 | 0.67 | 0.49 | 1.32 | 8.4 | 8.3 | 1.9 | 77 |
| 25-04 | 0-40 | 8.79 | 0.131 | 0.06 | 0.61 | 0.37 | 0.66 | 6.8 | 3.2 | 1.6 | 26 |

**УЛААНБААТАР ХОТЫН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НУТАГТ ОРШИХ “ОРИКА МОНГОЛИА” ХХК-ИЙН
“ХИМИЙН БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЭЛ ХАДГАЛАХ АГУУЛАХ” ТӨСЛИЙН 2025 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Хүснэгт 3-5. Талбайн хөрсний хими шинж чанар /2025 оны 9-р сар/

| Зүсэлт дугаар | Дээж авсан гүн, см | pH /H ₂ O/ | EC _{2,5} /ds/m | Давс % | Ялзмаг % | CO ₂ % | иоз | Солилцоот суурь мг-экв /100 г | | Шим тэжээлийн элемент мг/100г | |
|---------------|--------------------|-----------------------|-------------------------|--------|----------|-------------------|------|-------------------------------|------------------|-------------------------------|------------------|
| | | | | | | | | Ca ⁺² | Mg ⁺² | P ₂ O ₅ | K ₂ O |
| Хөрс-1 | 0-20 | 8.04 | 0.224 | 0.11 | 1.65 | 0.82 | 1.51 | 14.8 | 9.7 | 2.7 | 18 |
| | 20-50 | 8.25 | 0.293 | 0.14 | 0.74 | 1.15 | 1.29 | 15.5 | 7.5 | 2.0 | 44 |
| Хөрс-2 | 0-20 | 8.36 | 0.428 | 0.21 | 3.23 | 2.63 | 2.18 | 25.8 | 9.5 | 5.3 | 114 |
| | 20-50 | 8.09 | 0.157 | 0.07 | 1.48 | 0.16 | 1.55 | 11.2 | 7.5 | 2.7 | 25 |

Хөрсний химийн шинжилгээний дүнгээр сайргархаг болон хужирлаг хүрэн хөрс ялзмагт бодисын агууламжаар бага, хөрсний дээд давхаргад 1.86-1.93%-ийн хооронд хэлбэлзэнэ. Талхагдсан хөрсний дээд давхаргын ялзмагын агууламж буурч багассан үзүүлэлттэй. Сайргархаг хужирлаг хөрс бусад хөрснөөс давсны агууламжаар илүүтэй байгаагаар ялгаатай байна. Үүнтэй уялдаж хөрсний цахилгаан дамжуулах чанар хужирлаг хөрсөнд нэмэгдсэн байна. Нийт хөрсний урвалын орчин хөрсний 40-50 см гүн хүртлээ шүтлэг ихтэй байгаа нь онцлогтой. Хөрс хагас метрийн гүн хүртлээ бага зэргийн хэмжээний карбонат агуулсан байна. Шингээгдсэн сууриудын нийлбэр их биш 100 г хөрсөнд 10.0-21.7мг/экв хүрч, сууриудаас кальцийн ион зонхилно. Шим тэжээлийн бодисын хангамжаар ургамалд хялбар ашиглагдах хөдөлгөөнт элемент фосфорын агууламжаар харилцан адилгүй бага болон дунд зэргийн хангамжтай, харин хужирлаг хүрэн хөрсөнд калийн элемент илүүтэй агуулагдсан онцлогтой байна.

Хүснэгт 3-6. Талбайн хөрсний физик шинж /2025 он 4-р сар/

| Дээжний дугаар | Дээж авсан гүн /см/ | Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм-р | | | | | | | Механик бүрэлдэхүүн |
|----------------|---------------------|---|-----------|-----------|------------|-------------|--------|-------|---------------------|
| | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 | |
| 25-01 | 0-20 | 31,5 | 30,6 | 17,5 | 5,6 | 7,1 | 7,8 | 20,5 | Элсэнцэр |
| | 20-32 | 36,6 | 29,4 | 15,8 | 5,3 | 6,9 | 6,1 | 18,2 | Элсэнцэр |
| | 32-50 | 30,0 | 31,7 | 18,3 | 4,8 | 9,3 | 5,9 | 20,0 | Элсэнцэр |
| 25-02 | 0-10 | 33,8 | 24,2 | 27,0 | 2,6 | 6,5 | 5,8 | 15,0 | Элсэнцэр |
| | 10-40 | 38,8 | 29,9 | 13,7 | 4,8 | 6,8 | 6,0 | 17,7 | Элсэнцэр |
| 25-04 | 0-40 | 47,4 | 22,9 | 14,9 | 4,1 | 5,5 | 5,5 | 14,8 | Элсэнцэр |


Хүснэгт 3-7. Талбайн хөрсний физик шинж /2025 он 9-р сар/

| Дээжний дугаар | Дээж авсан гүн /см/ | Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм-р | | | | | | | Механик бүрэлдэхүүн |
|----------------|---------------------|---|-----------|-----------|------------|-------------|--------|-------|---------------------|
| | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 | |
| 25-01 | 0-20 | 32.2 | 26.1 | 16.1 | 7.2 | 7.2 | 11.2 | 25.5 | Элсэнцэр |
| | 20-50 | 28.4 | 29.5 | 19.4 | 7.3 | 6.6 | 8.9 | 22.8 | Элсэнцэр |
| 25-02 | 0-20 | 23.5 | 32.5 | 22.5 | 4.8 | 8.9 | 7.7 | 21.5 | Элсэнцэр |
| | 20-50 | 34.3 | 26.2 | 19.3 | 5.7 | 7.2 | 7.3 | 20.1 | Элсэнцэр |

Хөрсний механик бүрэлдэхүүний шинжилгээний дүнгээр нийт хөрс элсэнцэр бүрэлдэхүүнтэй, хөрсөнд “том” болон “дунд” ширхэгтэй элсэн фракци зонхилж байна. Хөрсний

нийт бүрэлдэхүүний 80-83%-ийг “физик” элс зонхилох ба хөнгөн чанарын элсэнцэр бүрэлдэхүүнтэй байна. Хөрсний дээд болон доод давхаргад элсэн фракцийн агууламж жигд тархалттай байна.

Зураг 2-1. Хөрсний агрохими шинж чанар



Хөрсөн дэх хүнд металлын агууламж

Хөрсөнд олон төрлийн хүнд металл зохих хэмжээгээр харилцан адилгүй агууламжтай агуулагдсан байдаг. Янз бүрийн химийн бодисонд төрөл бүрийн хортой хүнд металл болон органик бодис агуулагддаг. Аж ахуйн үйл ажиллагаанаас ялангуяа санамсаргүй тохиолдлоор хөрсөнд химийн бодисын асгаралт явагдсан, хадгалалтын горим алдагдсан химийн бодисыг хөрсөнд булах мөн авто машинуудын шатах тослох материал нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд асгарсан тохиолдолд хөрсөн дэх хүнд металлуудын агууламж ихсэх, хөрс, ургамал бохирдох, цаашлаад газрын доорхи усанд нэвчиж, хүн болон мал, амьтны эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг. Судалгааны явцад тус талбайд сөрөг үйл явдал ажиглагдаагүй болно.

Хүснэгт 3-8. Талбайн хөрсний хүнд металлын агууламж /2025 он 4-р сар/

| Дээжний дугаар | Дээж авсан гүн, см-р | Хүнд металлын агууламж, мг/кг | | | | | |
|--|----------------------|-------------------------------|------|--------|--------|--------|--------|
| | | Ni | Cd | Pb | Cu | Zn | Cr |
| 2025/ 4-р сар Хөрс №3. | 0-2 | ND | ND | 0.76 | 20.70 | 89.38 | 1.16 |
| 2025/ 4-р сар Хөрс №4 | 0-2 | ND | ND | 0.81 | 16.51 | 105,61 | 1,66 |
| Хүлцэх агууламж (MNS-5850-2019) | | 150,0 | 3,0 | 100,0 | 100,0 | 300,0 | 150,0 |
| Хортой агууламж (MNS-5850-2019) | | 1000,0 | 10,0 | 500,0 | 500,0 | 600,0 | 400,0 |
| Аюултай агууламж (MNS-5850-2019) | | 1800,0 | 20,0 | 1200,0 | 1000,0 | 1000,0 | 1500,0 |
| Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ | | стандарт (MNS 5850-2019) | | | | | |

Хүснэгт 3-9. Талбайн хөрсний хүнд металлын агууламж /2025 он 9-р сар/

| Дээжний дугаар | Дээж авсан гүн, см-р | Хүнд металлын агууламж, мг/кг | | | | | |
|--|----------------------|-------------------------------|------|--------|--------|--------|--------|
| | | Ni | Cd | Pb | Cu | Zn | Cr |
| 2025/ 9-р сар Хөрс №-3. | 0-5 | 13.23 | ND | 16.56 | 17.69 | 107.7 | ND |
| 2025/ 9-р сар Хөрс №4 | 0-5 | 18.51 | ND | 26.61 | 23.6 | 94.2 | 7.07 |
| Хүлцэх агууламж (MNS-5850-2019) | | 150,0 | 3,0 | 100,0 | 100,0 | 300,0 | 150,0 |
| Хортой агууламж (MNS-5850-2019) | | 1000,0 | 10,0 | 500,0 | 500,0 | 600,0 | 400,0 |
| Аюултай агууламж (MNS-5850-2019) | | 1800,0 | 20,0 | 1200,0 | 1000,0 | 1000,0 | 1500,0 |
| Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ | | стандарт (MNS 5850-2019) | | | | | |

Зураг 2-2. Хөрсний хүнд металлын түвшин



Тус агуулахын талбайн хөрсөн дэх хүнд металлын агууламжийг тодорхойлсон шинжилгээний дүнгээс харахад эдгээр хүнд металлын элементүүдийн агууламж хөрсөнд харилцан адилгүй хэмжээгээр агуулагдсан байна. Үүнд: **Хром (Cr)**-ийн агууламж 1.16-26.4 мг/кг, **Кадми (Cd)**-ийн агууламж 2025 оны хөрсний дээжинд тодорхойлогдоогүй буюу илрээгүй байна. **Хартугалга (Pb)**-0.76-102.6 мг/кг, **Цайр (Zn)**- 34.8-105.61 мг/кг, **Никель (Ni)**-ийн хэмжээ 2025 оны дээжинд илрээгүй **Зэсийн (Cu)**-ийн агууламж 6.51-45.9 мг/кг-ийн хооронд тус тус хэлбэлзэж агуулагдсан байна. Эдгээр агууламжийн хэмжээ нь Монгол улсын Хөрсний бохирдуулагч бодисын стандарт болох **“Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019 стандарт”-ийн** Хүлцэх агууламжийн хэмжээнээс хэд дахин бага байна.

ДҮГНЭЛТ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг цаг тухай бүрд нь даган мөрдөх ажлын хүрээнд 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулан байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн тайланг мэргэжлийн байгууллагатай хамтран тайлагнаж байна.

“Орика Монголиа” ХХК-ийн “Химийн бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах агуулах” нь Улаанбаатар хотын Багахангай дүүргийн нутагт байрладаг. Олон улс болон Монгол улсын стандарт шаардлагад нийцсэн химийн бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах зорилготой. Агуулах нь химийн бодис хадгалах зориулалтын тавиуртай, зохиомол гэрэлтүүлэг хүрэлцээтэй, агаар сэлгэх салхивчтай, хана, шал нь химийн бодис хадгалахад тэсвэртэй материалаар хийгдсэн, 24 цагийн харуул хамгаалалттай. Төслийн талбайд нийт 12 ангор байрлаж байгаагаас “Орика Монголиа” ХХК нь 8 агуулахыг Зэвсэгт хүчний агаарын цэргийн 337 дугаар ангиас түрээслэн ашигладаг. Одоогийн байдлаар нийт 8 агуулахаас 5 хоосон, 3 агуулахад хадгалалтыг хийж байна. “Оюу толгой” ХХК-ийн лицензийн талбайд байрлах Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрлүүгээ түүхий эд буюу химийн бодис, тэсэлгээний хэрэгслийг зориулалтын тээврийн хэрэгсэлээр цагдаагийн хяналтан дор энэ төрлийн зөвшөөрөлтэй гэрээт компаниар гүйцэтгүүлдэг.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан хэрэгжүүлэх арга хэмжээний хувьд ажилчдыг хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангасан хамгаалалтын хувцас, хэрэглэл, ам, хамрын хаалт, чихэвч, чихний бөглөө, бээлий, гутал, нүдний шил зэргээр ханган ажилладаг. Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл болон ажлын явцад ажилчид гэмтэж бэртэхээс урьдчилан сэргийлж, сургаж дадлагажуулах, эмнэлгийн анхан тусламжийн хайрцгийг байрлуулах зэргийг хийж гүйцэтгэсэн. Гэнэтийн болзошгүй галын аюулаас сэргийлэх, гал гарсан тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, гал унтраахад шаардлагатай багаж хэрэгслийг талбайд байршуулсан бөгөөд Багахангай дүүргийн онцгой байдлын газартай хамтран ажилчдыг чадавхжуулах урьдчилан сэргийлэх, сургалтанд хамруулан ажилладаг байна. Мөн химийн болон бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлт, хадгалалтын горим зөрчигдөх, гэнэтийн осол, санамсар болгоомжгүй байдлаас химийн бодис асгарч алдагдах, тэсэрч дэлбэрэх тохиолдолд ашиглах багаж, хэрэгсэл, шингээгч материал, хувийн хамгаалах хэрэгслийг ажлын байранд байршуулж, ажилчдад ашиглах дадлыг эзэмшүүлсэн байна.

Багахангай дүүрэг дэх “Орика Монголиа” ХХК-ийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнд Хайлаас 150 ширхэг, Голт бор 20ш тус тус 170 ш мод тарьсан.

Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдал нь аюултай хог хаягдлын ангилалд багтах бөгөөд 2024 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах эрх бүхий “Элемент” ХХК-тай “Химийн хорт болон аюултай бодисын хаягдал тээвэрлэх, устгах №ХБ-25/028 тоот гэрээ”-г 1 жилийн хугацаатай байгуулсан. Тус гэрээнд хог хаягдлыг ангилан ялгаж “Аюултай хог хаягдал” гэсэн тэмдэглэгээтэйгээр шилжүүлэх бөгөөд аюултай хог хаягдлын тоо хэмжээг тодорхойлон тээвэрлэлтийг тусгай зөвшөөрөл бүхий ААН-ийн тээврийн хэрэгслээр гүйцэтгэхээр заасан байна.

Ахуйн хуурай хог хаягдалыг Багахангай дүүргийн тохижилт үйлчилгээний компанитай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулан жил бүр сунган хамтран ажиллаж байна.

Нийгмийн хариуцлагын хүрээнд Монгол улсад хэт холын марафон гүйлт үүсэж хөгжсөний түүхт 66 жил, Холбоо байгуулагдсаны 15 жилийн ойн хүрээнд 14 дэхь жилдээ 2025.05.03-ны өдөр Багахангай дүүрэгт амжилттай зохион байгуулагдсан. Тус арга хэмжээний хүрээнд “Орика

Монголиа” ХХК нь ивээн тэтгэн оролцсон. Мөн Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн 63.2 м² цонхыг шинээр солиж суурилуулсан.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн агаар, хөрсний чанарын хяналт шинжилгээний хүрээнд хавар, намар агуулахын талбай орчмын 2 цэгт агаарын хэмжилтийг хийж гүйцэтгэсэн. Нийт тоосны агууламж, хүхэрлэг хийн агууламж, азотын давхар ислийн агууламж, дуу шуугианы агууламж Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2025 стандартад заагдсан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлт байхгүй буюу стандарт хэмжээнд байна.

“Орика Монголиа” ХХК-ийн талбай орчмын хөрсний мониторингийн цэгүүдийн өнгөн хөрс (0-10 см)-ийн түүвэрлэн авсан 2 ширхэг дээжинд Кадми (Cd), Хром (Cr), Зэс (Cu), Молебден (Mo), Никель (Ni), Хар тугалга (Pb), Цайр (Zn) зэрэг элементүүдийг тодорхойлуулахад Монгол улсын Хөрсний бохирдуулагч бодисын стандарт болох **“Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019 стандарт”-ийн** Хүлцэх агууламжийн хэмжээнээс хэд дахин бага агууламжтай байна.

Улаанбаатар хотын Багахангай дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжиж байгаа “Орика Монголиа” ХХК-ийн химийн бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах агуулах төсөл нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар Багахангай дүүргийн 1-р хорооны иргэд, нийслэлийн байгаль орчны газар, БОУАӨЯ-д тайланг жил бүр хүргүүлэн дүгнүүлж ажиллаж байна.

ХАВСРАЛТУУД